



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/383

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "д", Жижиг дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.6, 8.1.9, 8.1.10, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.1, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх, орон нутгийн ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагааг сайжруулах, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхтуяа (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: П.Очирбат (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Ж.Мөнхбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
С.Бямбамаа (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн)
Т.Туул (Мерит төслийн Жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн)
Ө.Удвал (Мерит төслийн Дундговь аймаг дахь зохицуулагч)

Нарийн бичгийн дарга: Б.Цэрэнханд (Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэр, худалдаа үйлчилгээний албаны дарга)

2. Орон нутгийн аж ахуйн нэгж, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид, уул уурхайн компанийн хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх ажлыг үр дүнтэй шуурхай зохион байгуулж ажлын явцыг сар бүр тайлагнаж ажиллахыг дэд ажлын хэсэг (Д.Энхтуяа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210522